

ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХЬ МОНГОЛЫН ТҮҮХИЙН СУДАЛГААНЫ
ЗАРИМ АСУУДАЛ(XIV зууны II хагасаас XVIII зуун)

Д.Энхтүвшин¹

Түүхүүр үг: Монгол улс, улс орны хил хязгаар газар нутаг, XVII зууны эхэн, XVII зууны эцэс, XVIII зууны 50-иад он,

Монголчууд хүчирхэгжин мандаж дэлхийн түүхийг идэвхитэй бүтээлцсэн “Эзэнт гүрэн”-ий үеийн түүхийг анхааран судалж олон тооны ном зохиол хэвлэгдсэн байна. Харин, хүчирхэг нэгдмэл байдал задарч, Монгол улсын төрийн төв эх нутагтаа шилжин ирсэн XIV зууны II хагасаас XVIII зуун хүртэл үеийг анхаарал хандуулан судлах шаардлага зайлшгүй чухал юм. Судалгааны өнөөгийн түвшинд нэр томъёо, үзэл баримтлалын хувьд багагүй зөрөөтэй тул шинэсанаа гаргалгаа дэвшүүлэх, Монгол улсын төрийн бодлогын залгамж холбоог тодруулах, шинэ баримт хэрэглэгдхүүнийг судалгааны эргэлтэнд оруулах зайлшгүй чухал байна.

Түүхийн судалгаан дахь аль нэг өнцгөөс Монголын түүхийг судлахаас илүүтэй бид өөрөөрөө төвлөн, тухайн цаг үеийн түүхийг судлах, урьд өмнө судалгааны эргэлтэнд төдий л ороогүй монгол, хятад, түвэд, манж, хэлний сурвалж хэрэглэгдхүүнийг ашиглан тухайн үеийн түүхийг судлах, нөхвөрлөх оролдлого хийх, өмнөх судалгааны хүрээнд нэг мөр болоогүй ойлголтууд: улсын нэрийдэл, тухайн үеийн түүхийн үргэлжлэх цаг хугацаа, улс орны хил хязгаар газар нутгийн зэрэг асуудлуудад судлаачдын анхаарал хандуулахыг оролдон.

Хятад дахь Юань улсын ноёрхол халагдан, хаант төр уугуул нутагтаа шилжин, хөрш улс тэмүүдтэй хил залган орших болсноор манай Монгол улсын түүхийн нэгэн үе эхэлдэг. Монголчууд дэлхийн түүхийг идэвхитэй бүтээлцсэн цаг үе нэгэнт ард хоцорч, төр улсыг удирдах эзэн ханы хүч чадал засаглах чадвар, эрх мэдэл нэр хүнд суларч, томоохон язгууртан ноёдын эдийн засагцэрэг улс төрийн бие даасан байдал бэхжин, дотоодын зөрчил тэмцэл хурцдан, улс орны нэгдмэл хүчирхэг байдал улирч одсон нь улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төрийн тусгаар тогтнол алдагдахад хүрсэн нь тухайн үеийн монголын түүхийн гол онцлог байв.

1. Дурьдан буй үеийн түүхэнд олон асуудал нэг мөр болоогүй олон асуудал байна Юуны өмнө, *Улсын нэрийдлийн хувьд* сурвалж мэдээ, эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд ойролцоогоор 20 орчим томъёолол байна. Үүнээс зармыг нь дурьдвал:

1. Монгол Улсын Их Сургууль

Д. Энхцэцэг

Нэгдүгээрт. Мин улсын түүх, сурвалж бичгээс улбаалан хожмын хятад болон өрнө, дорнын судлаачдын зохиол бүтээлд өгүүлэгдэн буй үеийн “Монгол улс тусгаар улс болохыг үгүйсгэсэн” санаа өнө удаан хадгалагдаж ирсэн “Мин улс бол нэгдэлтэй (нэгдмэл) улс, Монгол бол Мин улсын төвийн эрхийн (төв захиргааны) харьяан дахь нэг газар орныг хэсэглэн эзэлсэн хүчин болно”² гэж үзэх болохоор “*Мин улсын үе дэх Монгол*” (明代蒙古) гэж нэрлэж иржээ. Хэдийгээр “албан бус” хэллэг гэх боловч Буянхүү³, Дарийжав⁴, Асралт⁵, Жимс, Эрдэнэтогтох, Вада Сей⁶, Д.Покотилов⁷, Харада Ёошито⁸, Хагирава Жюнпей⁹, Морикава Тэцуну¹⁰ Serjus, Н¹¹ зэрэг олон судлаачдын бүтээлд энэ нэр тэмдэглэгдсэн. Эдүгээ хятадын зарим эрдэмтэд “Мингийн үеийн монгол” гэдэг нь тухайн үеийн монгол нь Мин улсад харьяалагдахыг заасан биш “Мингийн үе дэх” буюу “цаг үеийг заасан явдал болно... Цаг хугацаа нь 1368-1634 он”¹² болохыг тодотгон тэмдэглэх болсон ч агуулгын хувьд дээрхи санаатай адил юм.

Хоёрдугаарт. Сүүлийн жилүүдэд Хятад нэн тэргүүнд Өвөр монголын түүхчид шинэ сурвалж хэрэглэгдхүүнд түшиглэн олон асуудлыг тодруулан, “Умард Юань улсын түүх” гэж нэрлэх болжээ. “*Умард Юань улс*”, (北元) (“Хойд Юань улс”, “Ар Юань улс”) хэмээх нэрийн талаар авч үзвэл Аюуширидара хааны (1370-1378) үеэс үүсч, XIV- XVII зууны Монголыг ийнхүү нэрлэж байсан гэж зарим судлаачдын бүтээлд дурьджээ

1373 онд Монголын хаан Аюуширидараас Бөтгөмөр, Эсэнбуха хоёр элчийг зарж, Солонгосын хойгт оршиж байсан Корё улс (918-1392)-ын Кониминь ванд илгээсэн Жуу бичигт¹³: “Сүүд үес дайн самуун дэгдсний улмаас умар зүгт саланги нэгээрээ ишилжин суув. Эдүгээ Хохтомөрийг чинсян тавьж, сэргэн мандах цаг хэзээ мөдгүй болов. Ван та бас Шизу-гийн удмын хун тул тэнгэрийн дорхийг дахин засахад хүч хавсаргаас зохимуй”¹⁴ хэмээн өгүүлсэн нь анх “умар зүгт ишилжин суув” дурьдсаныг үндэслэн “... хаан Аюуширидара цагаан нохой жил (1370) Инчанд суурин залгаад оны нэлээд Срюань Гуан гэж өөрчлөн (улсаа) Умард Юань гэж нэрийдэн”¹⁵ хожмын түүхчид адил тэмдэглэх болжээ. Түүхч Рашипунцаг: “... Тэндээс Шун-Ди хааны...хун тайж Аюуширидара 34 насандаа ... Инчанфу хотноо хааны ор тавцан дор залгамжилж, Хойд Юань улс хэмээн нэрийдээд Хотол Монгол улсаа эзлэн сууваа...”¹⁶, Дарма гүүш: “Билигт хаанаас Лигдэн хутагт хүртэл умар

2. *Дай Хуни, Буян* Умард Юаны түүх. Хайлар, 1991, тал.3

3. Мин улсын үеийн монголын түүхийн тухай. Тайби., 1998

4. Дарийжав. Мин улсын үеийн говийн өмнөх хэсгийн монголчуудын түүхийн судалгаа. Хөх хот., 1998

5. Мин улсын үеийн монгол ба дундад улсын худалдааны харилцаа. Бээжин., 1964

6. Мин улсын үеийн монголын түүхийн тухай өгүүлүүдийн эмхтгэл. Дээд, доод дэвтэр. Бээжин., 1998

7. Д.Покотилов. История восточных монголов в период династии Мин (1368-1634) по китайским источникам. СПб., 1893

8. Харада Ёошито. Мин улсын үеийн монгол. “Дорнод Азийн добүнкэй мэдээлэл” 108, 109, 111, 112. 1908-1909

9. *Хагирава Жюнпей*. Мин улсын эхэн үеийн умард хязгаарын тухай. “Дорно Азийн түүх судлал” 19-2. Токио., 1960; Өн улсын сүйрэл ба мин улсын эхний үеийн монголчууд. “Мин улсын үеийн Монголын түүхийн судлал”. Токио., 1980 (засан хянаж, дахин хэвлүүлсэн)

10. *Морикава Тэцуну*. Мин улсын үеийн Монголын хагацал тэмцлийн үе. “Азийн түүх ба соёл 7. Умард Азийн түүх” Токио., 1999

11. *Serrius H.* Sino - Mongolian Relations during Ming... (1400-1600). Brussels., 1967

11. Дундад улсын монгол судлалын тойм. Эрдэнэтогтох, Жимс нар найруулав. ЛҮХХ., 2002

13. Конминь вангийн 22 дугаар оны 2 дугаар сарын хөхөгчин гахай өдөр

14. Ц.Цэрэндорж. Аюуширидар хаанаас 1373 онд Корё улсын ванд илгээсэн жуу бичиг хийгээд Умард Юань, Корёгийн харилцааны асуудал. МУБИС-ын Эрдэм шинжилгээний бичиг. ACTA HISTORICA. Tomus X. Fasc-2, тал 195-196

15. Мөн тэнд, тал.9

16. *Рашипунцаг*. Болор эрхи. Хөх хот., 2000, тал.337

Д.Энхцэцэг

дахь Юань улсыг эзэлсэн хорин хааны төр шашиныг ямар мэт тэтгэсэн гутгаар дэвтэр оршивай”¹⁷ гэж Рашипунцаг, Дарма гүүш нар “Умар Юань улс нь XIV зууны II хагасаас XVII зууны дунд үе хүртэл манай улсын нэр байсан” гэж үзжээ. Дай Хуни, Буян нар: “Умард Юань түүх бол 1368 он(д) Юань улсын эцсийн хаан Тогоонтөмөр нийслэл Дайдугаас ухран гарч ... монгол орондоо буцснаас 1634 он, Чингис хааны алтан ургийн үе залгамжилсан эцсийн хаан Лигдэний цэрэг дарагдан, Хөх нуурт нас барсан хүртэл нийт 267 жилийн хөгжлийг өнгөрүүлсэн байна”¹⁸ гэж XIV зууны II хагасаас XVII зууны эхэн хагас хүртэл монголчуудын түүхийн бүхий л үеийг “Умард Юань улс” хэмээн томъёолсон нь өмнө дурьдсан нэрийдэлтэй харьцуулбал Мин, Монгол улс хоёул тусгаар улс гэсэн санааг заах мэт боловч нөгөө талаар “Умард Юань” хятад, монголыг нэгтгэсэн “Их Юань улсын үргэлжлэл” гэсэн утга агуулж байдаг. “Мин хийгээд Умард Юань, Монгол (Умард Юаньд үл хамаарагдах монгол)-ын тогтсон нь манай улсын түүхэн дэх гурав дахь удаагийн өмнөд, умарт төр болох юм...”¹⁹ гэж үзжээ.

Тэгвэл, Монгол түүхийн бусад сурвалж, судлаачдын бүтээлүүдээс нягталвал “Умард Юань улс”(北元) нэр байсан уу? Нөгөө талаар энэ нэрийдэл нь “өмнөд” “умард” төр, “түрүү” “хожуу” төр гэсэн хятадын уламжлалаас үүдэлтэй бий болсон байна. “Умард Юань улс”(北元) нэр зөвхөн хэсэг хугацаанд бүр тодруулбал, Аюуширидара, Төгстөмөр (Усгал) хаадын үе, 1370-1389 он хүртэл “20 орчим жил” зурвас үеийг зааж байсан бололтой. Аюуширидара, Төгстөмөр хаадын эзэмшилд Монгол улсын үндсэн төдийгүй, өмнөд хятадын зарим нэг муж, хойд хятадын үлэмж хэсэг нь харьяалагдаж байв. Усгал хаан таалал болсноор Их Юань улсын ноёрхлыг сэргээхийн төлөө монгол хаадын тэмцэл амжилтгүй болж, “Умар Юань” нэр хэрэглэгдэхээ больсон. Манай улсын эрдэмтэд ч энэ санааг баримталж байдаг. Харин Өвөр Монголын судлаачдын хувьд 1990-ээд оноос хойш бичигдсэн зохиолуудад тухайлбал Дай Хуни, Буян²⁰, Дамба “Умард Өн”{ханз}²¹, Жимс, Эрдэнэтогтох²², “Монгол Үндэсний нэвгэрхий түүх”, Даарийжавын сүүлийн үед бичсэн өгүүлэл мөн Японы эрдэмтэн Вада Сей²³, Honda Minoru²⁴ийн судалгаа, Christopher P. Atwood нарын бүтээлд “Mongol Northemltuar Dynasty”²⁵ буюу “Умард Юань” хэмээх нэрийг хэрэглэсэн байдаг.

Гуравдугаарт. Харь хэлний хятад, солонгос сурвалж төдийгүй монгол сурвалж бичгүүдэд тухайн үеийн улсын нэр хэрхэн тэмдэглэгдэн улирч ирсэн, судлаачид энэ талаар ямар саналтай байдгийг тоймлон тэмдэглэвэл: “Дөчин түмэн Их Монгол улс, Дөчин түмэн Монгол улс, Монгол улс, Арван түмэн Монгол улс, Зургаан түмэн Монгол улс, Дөчин дөрвөн хоёрын Монгол улс, Монгол Ойрадын улс” гэх зэргээр бичсэн байна.

Юуны өмнө “Дөчин түмэн Их Монгол улс” хэмээх нэрийн талаар авч үзвэл хожим Лигдэн хаан 1619 онд Зүрчидийн Нурхачид элч илгээн өөрийгөө “Дөчин түмэн Монголын эзэн”²⁶, XVII зууны монгол-оросын харилцааны бичгүүдэд Лигдэн хааныг “Чакир хаан”, “Дючин хаан”²⁷ гэж нэрлэж байснаас үзвэл Их Монгол улсын нэрийг бусад улстай харилцахад хэрэглэж

17. Дармагүши. Алтан хүрдэн мянган хигээст бичиг. Хөх хот., 1987, тал.109-128

18. Дай Хуни, Буян. Умард Юань түүх. Хайлаар.,1991, тал.8

19. Мөн гэнд, тал.8

20. Дай Хуни, Буян. Умард Юань түүх. Хайлаар.,1991

21. Дамба. Умард Өнийн мандал буурал. Хөх хот.,1998

22. Дундад улсын монгол судлалын тойм. Эрдэнэтогтох, Жимс нар найруулав. ЛҮХХ., 2002

23. Вада Сей (Wada Sei) Умард Өнийн хаан угсааны тухай “Ичимүра (++) докторын далан насы ойд зориулсан дорнод Азийн түүхийн өгүүллэйн цуврал” Токно., 1933;

24. Honda Minoru “On the genology of the early Northern Yuan”, Ural-Altische Jahrbuster, XXX,3/4,1958; Хонда “Монголын үеийн түүх судлал”1991 онд дахин хэвлүүлсэн.

25. Encyclopedia of Mongolia and Mongol empire. By Christopher P. Atwood. New York., 2000

26. Манжийн үнэн магад хууль. УБ., 2009, тал.78

27. Русско-Монгольские посольские отношения XVIIв. М.,1956, с.147

Д. Энхцэцэг

байжээ. Эзэнт гүрний үед Дөчин түмэн бүхий байсныг хожим улс орон доройтохын хамт хүчирхэг үеийн бэлэгдэл болгон уг нэрийг хэрэглэсэн ч байж болох бөгөөд "XIV-XVII зууны үед Дөчин түмэн Монгол улс нэрийг аливаа сайн сайхан, хүчирхэгжилт, бүрэн бүтэн байдал, эрх сүртэйн бэлэгдэл болгон уламжлан хэрэглэж байжээ гэж үзүүштэй. "Арван түмэн Монгол улс", "Зургаан түмэн Монгол улс" нэр нь өмнө дурьдсан "Дөчин түмэн монгол" улсын нэрнээс улбаалан үлдсэн юм. "Арван түмэн монгол", "зургаан түмэн монгол" нь улсын нэр бус Улсын бүрэлдүүлж буй хэсгийг илэрхийлж буй нэр, их улс хэрхэн доройтсон бутран сарнисан болохыг илэрхийлж буй хэллэг гэж ойлгож болох юм.

"Дөчин дөрвөн хоёрын монгол улс", "Монгол Ойрадын улс" хэмээх нэрийн талаар манай сурвалж бичгүүд, судалгааны ном зохиол ихэвчлэн Тогоон тайшийн үе, Эсэн тайш монголыг нэгтгэн захирсан үе буюу Ойрадын манлайллын дор нийт монголчууд нэгдсэн тухай дурьдахдаа хэрэглэсэн байх юм. Тухайлбал Саган Сэцэн: "Тогоон, эдүгээ хамаг монгол улс миний боловоо", "Хэрэв Дөчин дөрвөн хоёр хагацан дайжваас", "тэндээс Дөчин дөрвөн хоёрыг цуглуулж", "Дөчин дөрвөн хоёр нэгэн амой", "Эсэн чи Дөчин дөрвөн хоёрын хаан болов", "Дөчин дөрвөн хоёрын төрийг барьсанд"²⁸, "Торгууд хааны тууж" хэмээх тод үсгийн дурсгал бичигт: "дуу жил (1640) Дөчин дөрвөн хоёрын хуучин эвдрэлээ уураад (болиод) санаа нэгдэж их цааз тогтоогоод"²⁹ гэх зэргээр дурьджээ. Мөн "БНМАУ-ын түүх (1966) хамтын бүтээлд "Дөчин дөрвөн хоёрын төр нэгдсэн"³⁰ гэж бичсэн ч хожим төдий л хэрэглэхгүй байжээ.

Түүхч М.Санждорж: "... Чингэлээр тухайн үеийн монгол улс нь оноосон нэргүй улс байсан бус түүхийн хайрласан "Дөчин дөрвөн хоёрын Монгол улс" хэмээн нэрлэхэд болохгүй зүйлгүй санагдана"³¹. Энэ саналыг үндэслэн Монгол улсын түүх таван боть зохиолд: "Дөчин дөрвөн хоёр", "Монгол улс" гэж аль алиныг нь хэрэглэсэн харагдаж байна.³² Энэ нэрийдэл нь түүх сурвалжийн мэдээг үндэслэвэл 1430-1450-аад оны дунд үе хүртэл 20 гаруй жилийн түүхэн үйл явдалтай холбогдох тул тухайн үеийн Монголын түүхийн гурван зуу илүү жилийн түүхийг илтгэн харуулах нэр болж хараахан чадахгүй ч нэг талаар баруун, зүүн Монголын тус тус бие даасан байдал эдүгээгийн ойлголтоор холбооны (федерацийн) улсын дүр төрхийг санагдуулж"³³ байгаатай холбон хойшид улам тодруулан судлах шаардлагатай юм.

XVII-XIX зууны монголчуудын сурвалж бичигт дээр дурьдсан олон нэрнээс гадна XIV-XVII зууны улсын нэрийг "Монгол улс" гэж тэмдэглэсэн нь бүрч олонтоо. Хүчирхэгжин мандсан, сулран доройтсон, эвсэн нэгдсэн энэ үеийг түүхийн бүхий л түүхийг өгүүлэхдээ түүхч Саган Сэцэн, Гүн Гомбожав, Лами, Жамбалдорж, Рашипунцаг бүгд л "Монгол улс" хэмээн нэрлэжээ. Иймээс, бидний бодоход манай Монгол улсын эртнээс улбаалсан эцэг, эхийн нэр мэт дотно, ямар нэг гоёж чимсэн, аль нэг цагийн аяст зохицсон элдэв тодотгол үгүй, даруу мөртлөө эрхэмсэг хүндтэй, цаг цагийн шуурганд орхигдон мартагдаагүй дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар улсын нэр бол *Монгол улс* юм. Цаашид ч "XIV-XVII зууны үеийн Монгол улс" гэж нэрийдэж тогтох нь зүйтэй санагдана.

28. Саган сэцэн. Эрдэнийн товч. Хөх хот., 1994, тал.304,316,322,329,330

29. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурварж бичгүүд III. УБ.,2002, тал.207-208

30. БНМАУ-ын түүх. УБ.,1966, тал.422

31. М. Санждорж. Монгол төрийн түүхээс (XIII-XIX зуун). УБ.,1998, гал.16.79

32. Монгол улсын түүх. Гутгаар боть. УБ., 2003, тал.31

33. М.Санждорж. Монгол төрийн түүхээс (XIII-XIX зуун). УБ.,1998, тал.83

Д.Энхцэцэг

2. Тухайн үеийн улс төрийн түүхэн нөхцөл байдлаас улбаалан *Монгол улсын хил хязгаар, нутаг дэвсгэр*³⁴ ихээхэн хувирамтгай, овог аймгуудын нүүдэл, шилжилт хөдөлгөөн их тул бидний хөндөж буй асуудалд бэрхшээлтэй зүйл багагүй байна.

Монгол эзэнт гүрний нэгэн хэсэг "Алтан ордон" улс задран унаж, XV-XVI зуунаас Оросын эзэнт улсын үндэс тавигдан эдийн засгийн өсөлт, дотоодод гарсан өөрчлөлтүүд, гадаад бодлого эрчимжин дорно зүгт буй ард түмнүүдтэй харилцаагаа өргөжүүлж, нутаг дэвсгэрээ дорно, өмнө тийш тэлэхэд хүргэжээ. Иймээс монголчууд *умард хязгаарын* заагийг тодорхой тэмдэглэдэггүй байсан явдал улирч, хязгаар нутгаа анхаарч, нутаг бэлчээрийн заагийг нарийн тодорхойлон тогтоох, түүнийгээ сахин хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарчээ. XVI зуунаас оросууд Сибирийн аймгуудыг нэгтгэн, хот шивээг байгуулан³⁵, умард Байгалын өндөрлөг хүрч, тухай үеийн Монгол улсын хамгийн хойд талаар оршин бүхий буриадуудтай айлсан суух болсон. Буриадын нутгийн хойд зах нь Байгал нуурын хойд бие, умард Байгалын өндөрлөгийн өмнө тал хүрч байсан тухайгаа "...эрт цагт сууж... асан Бидэ буряад зон Байгал далайн урьд, хойд биеэр нутагжин нүүнэ", "Байгал далай хойд бие руу Ойхон ольтриг руу зөөж нэг хэдэн жил суув. Гэдрэг буцаж далайн урьд биед нутагтаа нүүдэг болов", "Буриадууд Байгал далайгаа тойрон нутаглаж олон зууныг элээсэн юм" гэж тэмдэглэсэн³⁶ ийг үзвэл XVII зууны тавиад оноос өмнө Байгалын хоёр талаар Оросын хот шивээ байгуулагдахаас өмнө монголчуудын хойд хязгаар нь Байгал далайн чанал Лена мөрөн, Енисей мөрөн, Сибирийн наад захаар Хаант Оросын хил хязгаартай нийлж байв.

Зүүн, зүүн өмнөд хил хязгаар нь Фукой, Тайнин, Дойн хэмээх Урианхан гурван харуулын нутаг болно. Мин улс Монголын хилийн дагуу эдгээр харуулуудаас бүрдсэн хамгаалалтын бүс болгон, монголчуудыг хазаарлан барьж байх зорилготой "зими вэй" (хазаарлан барих харуулууд) гэж нэрлэсэн. Дойн харуул Цюлехэ (Цөл) голын дээд урсгал Доён уулын хавьд, Тайнин харуул өнөөгийн Гирин мужийн Гяорхэ (Тоорын) голын хөвөөнд, Фукой харуул Нон мөрөн, Цицикар хот орчим тус тус нутаглаж байжээ. Гурван харуул баруун талдаа "Их Хянган даваа, зүүн тийш Нон мөрөн (Нэзянь гол), зүүн өмнө этгээдэд Чанчун, Харбин, хойноо одоогийн Бутачи орчим"³⁷ хүрч, монгол сурвалжуудад Дойн харуулын монголчуудыг Урианхан, Тайнин харуулын монголчуудыг Онниуд, Фукой харуулыг Үжээд хэмээн тэмдэглэсэн байдаг. XV зууны 30-аад оны үест энэ гурван харуул Нон мөрөн, Шар Ус голоос өмнө зүг шилжин Цагаан хэрмийн гадна нүүдэллэх болжээ. Урианхан гурван харуулын нутаг дэвсгэр нь тухайн үеийн Монгол улсын эзэмшилд зүй ёсоор багтаж Монгол улсын зүүн, зүүн өмнө талын хязгаар нутаг нь байжээ гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм.

Энэ үед Монгол улс *өмнө талаараа* Цагаан хэрмээр Мин улстай хиллэж байв. Оросын эрдэмтэн Н.П.Свистунова "XIV зууны эцэс бол Мин улс хойд зүгт хилээ хамгийн ихээр тэлсэн үе хэдий боловч тухайн үед Хэтао (Ордос), Ляонин мужийн өмнөд хэсэг хийгээд Шаньси - Хэбэй - Өвөрмонгол болон Хэбэй - Ляонин - Өвөрмонгол гэсэн хэсэгхэн зурвас зааг газрыг эс тооцвол Цагаан хэрмээр зааглагдаж байв"³⁸ гэжээ. Мин улс монголчуудын довтолгооноос хамгаалахын тулд хойд хил дагуу бэхлэлтийн системийг шинээр, зарим газарт хуучин хэрмийн

34. Н.Ариунгуа, Д. Энхцэцэг. Монгол улс (XIV – XVII зуун) -ын хил хязгаарын газрын зураг. (Монгол улсын төрийн түүхийн музейн захиалгаар боловсруулав). УБ., 2006. Монгол улсын үндэсний атлас. УБ., 2009, тал. 36

35. Тара (1594), Кунгал (1593), Макабей (1618) Енисей (1619), Кирэнин (1631), Братья (1630), Дээд Ангар (1646), Баргужин (1648), Сэлэнгэ (1665), Дээд Шивээ (1616) шивээг тус тус байгуулсан.

36. Буриядай түүхэ бэшэгүүд. Улан-үдэ, 1998. тал.39; XIV-XIX зууны Монголын гадаад харилцаа. УБ., 1997, тал.121

37. Дамба. Умард Өнийн мандал буурал. Хөххот, 1997; Монгол үндэстний нэвгэрхний түүх. Думдад боть. Бээжин, 1995, тал.453

38. Н.П.Свистунова. Организация пограничной службы на севере Китая в эпоху Мин, Китай и соседи. М., 1980. с.183

Д.Энхцэцэг

суурин дээр байгуулжээ. Монголын өмнө талын хил нь үндсэндээ Н.П.Свистуновагийн судалж тогтоосноор байсан гэж үзэж болно.

XIV-XVI зууны үеийн Монгол улсын хил хязгаарын *баруун өмнө тал нь* Хатан голын баруун хэсэг, Хөх нуур, Хэси, Ганьсу мужийн хойд зах, Цагаан хэрмийн Цзяюйгуань боомтоос баруун тийших нутаг болно. Эдгээр нь эрт цагт Цагадай, Өгэдэй нарын удмыхны эзэмшил газар байсан бөгөөд XIV зууны сүүлээр Мин улсын баруун тийш хийсэн аян дайны үр дүнд Цзяюйгуань боомтоос баруун тийш орших монгол аймгууд Мин улсад бууж өгснөөр Хами, Андин, Адуань, Цюсянь, Ханьдун, Шажоу, Чизин харуулыг байгуулсан юм. Андин, Адуань, Ханьдун, Цюсянь харуул Синин, Хөх нуурт, Хами, Шажоу, Чизин харуул Сининээс Жуанлань (өнөөгийн Ганьсу мужийн Юндэн хошуу) хүртэлх нутагт байжээ. Гэвч Мин улс нь тус бүс нутгийг хяналтандаа бүрмөсөн авч чадаагүй тул харуулын монголчууд үндсэндээ тусгаар байсаар Хами, Шажоу, Чигин зэрэг монгол харуул монголчуудын шууд захиргаанд 1440-50-аад оны үес орсон байна. Монголчуудын дотоод зөрчил, улс төрийн таагүй байдлаас шалтгаалан эдгээр харуулын зарим нь уугуул нутгаа XV зууны 40-өөд оноос хойш орхисон бол нөгөө хэсэг нь XVI зууны 50 оноос эхэлсэн Ордос, Түмэдийн ноёдын баруун зүгт хийсэн аян дайны явцад тэдгээрийн эзэмшилд шилжив. Түмэдийн Алтан хан 1560 онд Хөх нуур руу цэрэглэж эзлээд хүү Бингид Ханьдун харуулыг эзэмшүүлэн, Хөх нуур, Ганьсу дахь монголчуудын хүч нэмэгдэж тэр хавийн Түвэдүүд ч дагаар орох болжээ. Мин улс Хөх нуур, Ганьсу дахь монголчуудын нөлөөг устгах зорилгоор цэрэг илгээсэнд Түмэдийн ноёд хэсэг хугацаанд Хөх нуур, Ганьсуг орхиход хүрсэн ч 1610 оноос Түмэдийн Холочи, Юншээбүүгийн ноёдын хамт дахин Хөх нуурыг эргүүлэн авсан³⁹ байна. Тиймээс энэ үед Монголын баруун өмнөд хил хязгаар нь Хөх нуур, Ганьсу мужийн хойд зах, Цагаан хэрмийн Цзяюйгуань боомтоос баруун тийших нутаг байжээ гэж үзлээ.

Монгол улс *баруун талаараа* эхэн үед Могулистантай хожим нь Казакын жузуудтай хил залган сууж байсан юм. Монголын хамгийн баруун талд Ойрад аймгууд нутагласаар ирсэн. Могулистаны захирагч Булагтөмөр хаан Или-ээс Болор, Куньлунь хүргэлх нутгийг бүрэн эзэмшиж байсан тул XVI зууны үед ойрадуудын нутгийн баруун зах Или мөрөнд ч хүрэхгүй байв. Хожим нь л Ойрадууд Балхаш нуур, Долоон Усны хөндий, Төмөрт нуур хүрч нутаглах болжээ⁴⁰ гэх эрдэмтэн Ж.Гэрэлбадрахын судалгааг оновчтой болжээ хэмээн үзлээ.


Ийнхүү XIV зууны II хагасаас XVII зууны үед Монгол улс нь Байгал нуураас чанадаас Цагаан хэрэм, Ляодуны хойгоос Дундад Ази хүргэлх уудам газар нутгийг эзэмшиж байжээ. Эдгээр өргөн уудам газар нутаг нь тухайн үед тархай бутархай байсан боловч нутаг дэвсгэртээ эзэн болж чадаж байсны тод жишээ юм. Тухайн үеийн Монголын түүхийн мэдээ баримтын зөрүү, түүхэн нөхцөл байдал зэргээс шалтгаалан тухайн үеийн Монгол улсын хил хязгаарыг нарийн яв цав годорхойлох боломж бага байгаа хэдий ч тэр үеийн Монгол улсыг дүрслэхдээ нэлээд барагцаалан гаргахаас өөр аргагүй байна.

39. Монгол үндэстний нэвтэрхий түүх. Думдал боть. Бээжин.,1995. тал.552-553

40. Ж.Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр хил хязгаарын түүх. УБ., 2002. тал. 87

Д.Энхцэцэг

МОНГОЛ УЛС XIV-XVII зуун



3. Бидний судлагдхуун болгон авч үзэж буй түүхэн үйл явцын **цаг хугацааны хамрах хүрээний талаар** “XIV зууны II хагасаас XVII зууны тэргүүн хагасын үеийн монголын түүх”, “Феодалын бутралын үе”, “Монголын төрийн бутралын үе”, “Монголын төрийн төв эх нутагтаа төвлөсөн үе”, “Эзэнт гүрний дараахь үе”, “Их гүрний хойших үе”, “Мин улсаас ван өргөмжилж зассан үе”, “Самуурлын үе”, “Мингийн үеийг монгол”, “Умард (ар, хойд) Юаны үе”, “После Юаньский период”, “Бага хаадын үе” гэж олон янзаар тэмдэглэж ирсэн. Аливаа ард түмний түүхийн ерөнхий үечлэлд төр-улс, газар нутаг, түүхэн цаг үеийн онцлог, цаг хугацааны шинжтэй ойлголтуудыг нэгдмэл байдлаар бие биетэй нь нөхцөлдүүлэн авч үздэг болохоор **бид**, Монгол улсын түүхийн нэгэн үе, хэдийгээр улсын нэрийн тухайд олон янзаар томъёолон ямар нэг шинэ содон томъёолол, улс төрийн үйл явцаас улбаалан нэрлэх нь төдий л зохимжтой бус тул Монгол улсын түүхийн ерөнхий үечлэлд хамааруулан, цаг хугацааны хязгаартайгаар ойлгох нь зүйтэй гэж бодож байна .

Туурга тусгаар Монгол улсын хил хязгаар нутаг дэвсгэрийн хамарч байсан хүрээг харгалзах, түүхийг эдүгээчлэн үзэх ялангуяа, тухайн үеийн Монголын түүхийг одоогийн ойлголтоор ӨМӨЗО, Шинжаан Уйгарын өөртөө засах орон, ОХУ-ын Буриад, Алтайн хязгаар, Их Хянган аймаг, Улаан хад, Ляонин мужийн монголчууд манай Монгол улсын нутаг гэж тус тус саланги тусгаар байдлаар авч үзэх боломжгүй. Тэр үед **Монгол нэрт нэг улсын** хүрээнд багтаж байсныг харгалзан үзэх нь арга зүйн хувьд зүйтэй юм.

Цаг хугацааны хувьд, XIV зууны II хагасаас (1368 он) тухайн үеийн түүх эхэлдгийг судлаачид хүлээн зөвшөөрдөг. Харин хэдий хүртэл үргэлжилсэн болох талаар нэгдмэл бус ойлголт уламжлагдан иржээ. Үүнд :

Нэгдүгээрт. Монгол улсын түүх (XIV зууны II хагасаас XVII зууны тэргүүн хагас)⁴¹ гэж үзэх нь их төлөв Алтан урагт Лигдэн хутагт хаан 1634 онд нас нөгчин, 1636 онд өмнөд Монголын олон аймаг Манжид эзлэгдсэнтэй холбоотой Хятад дахь монголын түүхийн судалгаа, өнөөгийн ӨМӨЗО-ны түүхчдийн бүтээлүүдэд баримталж буй чиг хандлага юм.

41. Дэй Хуни, Буян. Умард Юаны түүх. ӨМСХХ.,1991; Дарийжав. Мин улсын үеийн говийн өмнөд хэсгийн монголчуудын түүхийн судалгаа. Бээжин.,1997; Дундад улсын монгол судлалын тойм. ЛҮХХ., 2002; Жамбадорж. Болортоль. Хөххот.,1994; Ломи. Монгол боржигид овгийн түүх. Хөх хот.,1989; Лувсанданзан. Алтантовч. УБ.,1970; Лий Жин Сүэ. Монголын хураангуй түүх. Хөх хот.,1998; Монгол улсын түүх.гутгаар боть.УБ., 2003

Д.Энхцэцэг

1636 оноос өмнөд Монгол Манж улсын улмаар ДИУ, БНХАУ-ын бүрэлдхүүнд багтах болсон тул хятадын түүхийн уламжлалт Династын үечлэлийн дагуу энэ үеийг Мин (1368-1644), Чин (1616-1911) династын түүхэнд хамааруулан ойлгодогтой шууд холбоотой. Хятад дахь энэ үечлэл дэлхийн бусад орон дахь (Орос, Япон, Солонгос, АНУ зэрэг) тухайн үеийн монголын түүхийн судалгаанд уламжлагдан ирсэн. Өмнөд Монгол манжид эзлэгдсэнээр Монгол улс, Монгол төр мөхсөн гэвэл дэндүү ташаа зүйл юм. 1636-1691 он хүртэлхи нийт монголчуудын түүхийг Манж Чин улсын бүрэлдхүүнд багтаан авч үзэх нь хэр оновчтой хийгээд улс үндэстний эрх ашигт хэрхэн нийцэх бэ? гэдгийг нягтлах нь зайлшгүй чурал юм.

Хоёрдугаарт. Монгол улсын түүх (XIV зууны II хагасаас XVII зууны II хагас) гэж үечилдэг. Манжийн хаан Долоннуурт ирж (1691 он) Халх монгол, Манжид даган орсныг илтгэх чуулган чуулж⁴², дараа онд нь (1692) Халхын ноёдод “хошуу захирах тамга” олгосноор⁴³ “Халхчууд... 50 гаруй жил тусгаар тогтнолоо хадгалж байгаад манжид эзлэгдсэн”⁴⁴. “Халхын хаант улс” оршиж байсан нь “Монголын төр улсын уламжлал тасраагүй”⁴⁵ гэсэн санааг сурвалж хэрэглэгдхүүн болон судалгааны зохиолуудад дурьсан байдаг. Монгол улсын төв манай нутгаар төвлөн, Чин улстай зэрэгцэн бие даасан тусгаар бодлого явуулан, төр улс оршин буйн үндсэн шинж эртний уламжлалт Чингис эзний удмын Алтан урагт хаант төрөө төвхнүүлжээ. Хубилай хаанаас хойшхи төр-шашин хоёр ёсыг эрхэм болгон хагас зуун жил дотоод, гадаад бодлого явуулж ирсэн нь эш баримтаар тогтоогдож байна. Шашин төрийг хослон барьсан Богд хаант төр ёс уламжлан XX зууны эхэнд бидний монголчууд тусгаар тогтнолоо тунхаглан, эдүгээ бүрэн эрхэт Монгол улс оршин буйн үндэс болсон тул манай түүх судлалд энэ үеийг баримталдаг.

Гуравдугаарт. Дээрхи бүхнээс улбаалан 1690-ээд оноос Монголын төрийн төв болсон Халх монгол манжийн захиргааг хүлээх болсноос хойш 1691-1758 он хүргэл жар гаруй жил монголчуудын нэг хэсэг - Ойрад монголчуудын түүхийн асуудал зүй ёсоор тавигдана. 1630-аад онд хүчирхэг хаант төрөө тунхаглан монголчуудын төдийгүй бүс нутгийн түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэж, Монгол улсын төрийг улбаалан, тусгаар тогтнолыг эрхэмлэн амжилттай гадаад, дотоод бодлого явуулж ирсэн билээ. Тусгаар тогтнолын асуудал, төрийн бодлогын үндэс залгамж шинжтэй болохоор *Монгол улсын түүх (XIV зууны II хагасаас XVIII зууны 50-иад он)* гэж авч үзэж болно. Ийнхүү, олон янзын ойлголт, үечлэл зэрэгцэн оршсоор байгаа нь түүхчид монголын түүхийн үечлэлийн асуудлаар нэгдмэл үзэл баримтлалд хүрч чадаагүйтэй холбоотой. Монгол улсын түүхийн ерөнхий үечлэлийн асуудлыг эргэн харах, монгол үндэстний эрх ашгийг дээдлэх үүднээс аливаа асуудлыг эдүгээчлэх хандлагаас аль болох зайлсхийн нэгдмэл байр суурь баримтлах шаардлагатай байна.

Уламжлалт түүх бичлэг дэх үелэлийн асуудлыг эргэн харах, Дэлхийн улс орны түүхийг ажиглахад өөрийн улс төрийн тусгаар тогтнол алдагдсан үеийг хамгийн эмгэнэлт үе хэмээн үздэгчлэн, улс төрийн дотоодын зөрчил тэмцлийн улмаас тусгаар тогтнолоо алдсан, үндэстний хувьд хуваагдан, ертөнцийн хөгжил дэвшлээс хол хоцроход хүргэсэн Манжийн ноёрхлын он жилүүдийг Монголчуудын хүчирхэгжилтийн зуун - Их Монгол улс, Эзэнт гүрний үе, хөгжин дэвшсэн өнөөгийн XX, XXI зуунтай адилтган түүхэн үечлэлийн нэгэн шугаман дээр тавьж үзэж болж байна уу? гэдгийг эргэж харах хэрэгтэй болж байна.

42. Биеэр дайж өрнө, умрын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг. ӨМСХХ., 1992, тал.157

43. Биеэр дайж өрнө, умрын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг. ӨМСХХ., 1992, тал.184

44. БНМАУ-ын түүх. II боть. УБ., 1968, тал.93

45. Д.Гонгор. Халхын үүсэл ба Халхын хаант улс (XIV-XVII зуун) түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. УБ., 1967 он; Ли Бао-Вэнь. Дайчин улс ба Монголын Халхын хаант улс 1655 онд “Монголын түүхэнд холбогдох архивын баримтын судалгааны өнөөгийн байдал, цаашдын зорилт” олон улсын бага хурал, Токно., 2003, тал.157

Д.Энхцэцэг

Иймээс XIV зууны II хагасаас XX зууны эхэн хүртэл Монголын түүхийг нэгэн бүхэл үе болохыг онцлоод, дотор нь

Нэг талаас XIV зууны II хагасаас XVIII зууны дунд үе (1368-1758 он) хүртэл монгол оронд улс төрийн тэмцэл, задрал бутрал зонхилох болж үндэсний тусгаар тогтнол хэврэгшсэн тул бүхэлдээ улс орны эв нэгдлийг хангах, тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө тэмцлийн жилүүдийн түүх байсан.

Нөгөө талаас XVII зууны эхнээс манжийн түрэмгийлэл эхлэн, монгол улсын зах хязгаараас нь өөртөө нэгтгэснээр, XVIII зууны дунд үеэс XX зууны эхэн хүртэл Монгол улс тусгаар байдлаа алдан Чин гүрний зах хязгаар, хараат орон болж хувирсан гэж *хоёр шат* болгон үечилж үзэж болох юм.

Монгол улсын төрийн төв эх нутагтаа шилжин ирсэн XIV зууны II хагасаас XVIII зуун хүртэл үеийг анхаарал хандуулан судлах шаардлага зайлшгүй чухал юм. Судалгааны өнөөгийн түвшинд нэр томъёо, үзэл баримтлалын хувьд багагүй зөрөөтэй тул шинэ санаа гаргалгаа дэвшүүлэх, Монгол улсын төрийн бодлогын залгамж холбоог тодруулах, шинэ баримт хэрэглэгдхүүнийг судалгааны эргэлтэнд оруулах, энэ үеийн түүхэнд судлаачдын анхаарлыг хандуулах нь чухал байна.